

DeFacto

INDEPENDENT RESEARCH INSTITUTE

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ДОТООД

**АРДЧИЛЛЫН
ИНДЕКС**

2018

Улаанбаатар хот



Канадын гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр Азиийн сангас хэрэгжүүлж буй "Ардчилсан оролцоотойгоор төрийн албанд сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх нь" (STEPS) төслийн хурээнд Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын индексийг Дефакто институт гаргав.

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ДОТООД

АРДЧИЛЛЫН ИНДЕКС

2018

СУДАЛГААНЫ БАГ:

Б.Эрдэнэдалай (PhD), А.Бат-Оргил,
Г.Батхишиг, О.Батзаяа, Б.Сайханбаяр

АГУУЛГА

| | |
|---|----|
| Өмнөх үг | 8 |
| Судалгааны хураангуй..... | 9 |
| Судалгааны арга зүй..... | 10 |
| 1. Намын гишүүдээс авсан асуулга ба дотоод ардчиллын индекс | 12 |
| 1.1 Судалгаанд оролцогчдын мэдээлэл..... | 15 |
| 1.2 Улс төрийн намын дотоод ардчиллын индекс | 18 |
| 1.3 Улс төрийн намын гишүүдийн оролцоо | 19 |
| 1.4 Улс төрийн нам доторх өрсөлдөөн..... | 22 |
| 1.5 Улс төрийн намын ил тод байдал | 25 |
| 1.6 Улс төрийн намын санхүүжилт | 31 |
| 2. Экспертийн ярилцлага | 36 |
| Дүгнэлт..... | 38 |
| Ном зүй | 41 |

ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

| | | |
|------------|---|----|
| Зураг 1.1: | Судалгаанд оролцогчид, насны бүлгээр..... | 15 |
| Зураг 1.2: | Судалгаанд оролцогчид, хүйсээр | 15 |
| Зураг 1.3: | Судалгаанд оролцогчид, ажил эрхлэлтээр..... | 16 |
| Зураг 1.4: | Судалгаанд оролцогчид, байршилаар | 16 |
| Зураг 1.5: | Судалгаанд оролцогчид, намын харьяаллаар..... | 17 |
| Зураг 1.6: | Судалгаанд оролцогчид, боловсролоор | 17 |
| Зураг 2.1: | Судалгаанд оролцсон улс төрийн намуудын оноо | 18 |
| Зураг 2.2: | Судалгаанд оролцсон улс төрийн намуудын индекс | 18 |
| Зураг 3.1: | Улс төрийн намын гишүүдийн оролцоо | 19 |
| Зураг 3.2: | Улс төрийн намын даргыг хэн сонгодог эсэх | 20 |
| Зураг 3.3: | Намаас УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийг хэн тодруулдаг эсэх | 20 |
| Зураг 3.4: | Намын мөрийн хөтөлбөрийн боловсруулахад хэн оролцдог эсэх | 21 |
| Зураг 3.5: | Өнгөрсөн 4 жилд улс төрийн нам дотроо явуулсан бодлогын мэтгэлцээнүүдэд хэн оролцсон эсэх..... | 21 |
| Зураг 4.1: | Судалгаанд оролцсон улс төрийн намууд доторх өрсөлдөөн..... | 22 |
| Зураг 4.2: | 2016 оны УИХ-ын сонгуулиас хойш намын даргын сонгууль явагдсан эсэх | 23 |
| Зураг 4.3: | 2016 оны УИХ-ын сонгуулиас хойш удирдах зөвлөлийн сонгууль явагдсан эсэх | 23 |
| Зураг 4.4: | Намын дотоод бүтцийн байгууллагуудын сонгуульд нэр дэвших боломж нээлттэй эсэх | 24 |
| Зураг 4.5: | Намаас Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх боломж намын гишүүдэд нээлттэй эсэх | 24 |
| Зураг 4.6: | Намаас УИХ-ын сонгуульд өрсөлдөх боломж намын гишүүдэд нээлттэй эсэх | 25 |
| Зураг 4.7: | Намаас орон нутгийн сонгуульд өрсөлдөх боломж намын гишүүдэд нээлттэй эсэх | 25 |
| Зураг 5.1: | Судалгаанд оролцсон улс төрийн намуудын ил тод байдал..... | 26 |
| Зураг 5.2: | Намд дараах дотоод бүтцийн байгууллагууд байдаг эсэх..... | 27 |
| Зураг 5.3: | Өнгөрсөн 4 жилд намын дотоод бүтцийн байгууллагуудын сонгууль явагдсан эсэх | 27 |
| Зураг 5.4: | Нам доторх хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлдэг бүтэц ажилладаг эсэх..... | 28 |
| Зураг 5.5: | Намынхаа дүрэмтэй танилцсан эсэх | 28 |
| Зураг 5.6: | Намын үйл ажиллагааны тайлантай танилцах боломж нээлттэй эсэх | 29 |
| Зураг 5.7: | Намын интернет орчин дахь мэдээлэл..... | 29 |

| | | |
|------------|---|----|
| Зураг 5.8: | Намын өдөр тутмын үйл ажиллагаа, шийдвэрүүдтэй танилцдаг эх сурвалж..... | 30 |
| Зураг 6.1: | Судалгаанд оролцсон улс төрийн намуудын санхүүжилт | 31 |
| Зураг 6.2: | Намдаа гишүүний татвараа төлдөг эсэх | 32 |
| Зураг 6.3: | Намдаа хандив өгдөг эсэх..... | 32 |
| Зураг 6.4: | Гишүүний хураамж, хандивын талаарх зарцуулалтын мэдээлэл авдаг эсэх | 33 |
| Зураг 6.5: | Нам хөрөнгө, орлого, зарлагын мэдээллээ гишүүддээ мэдээллэдэг эсэх..... | 33 |
| Зураг 6.6: | Намын санхүүжилтийн талаарх мэдээлэл авах боломж гишүүддэд нээлттэй эсэх | 34 |
| Зураг 6.7: | Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлантай танилцдаг эсэх | 34 |
| Зураг 6.8: | Намынхаа сонгуулийн зардлын тайлантай танилцдаг эсэх..... | 35 |
| Зураг 6.9: | Төрөөс намд олгож буй санхүүжилтийн тайлантай танилцдаг эсэх..... | 35 |

ТАЛАРХАЛ

Энэхүү индексийг гаргахад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Азийн сан болон Канад улсын засгийн газар, арга зүйн талаас зөвлөгөө өгч, хамтран ажилласан Израйль улсын “Ардчилал” институт, Монголын “Нийгэм улс төрийн боловсрол төв”-ийн эрдэмтэн судлаачдад гүн талархал илэрхийлж байна. Мөн судалгаанд оролцсон нийт экспертууд, асуулгад цаг заваа харамгүй зориулсан улс төрийн намуудын гишүүдэд талархаж байна.

Та бүхний тусламж дэмжлэггүйгээр тус индексийг гаргах боломжгүй байлаа.

ӨМНӨХ ҮГ

“Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг” тогтоох судалгааг “Азийн сан” олон улсын байгууллагаас Улаанбаатар хотын 8 дүүрэг, 6 аймгийн 22 сумын нийт 1360 өрхийг хамарсан санамсаргүй түүврийн аргаар сүүлийн арван жилийн турш хийжээ. Уг судалгаагаар авлигад хамгийн их автсан байгууллагуудыг нийт 5 зэрэглэлээр эрэмбэлжээ. Монголын улс төрийн намууд 2010 оноос жагсаалтын тавдугаарт анх орж ирсэн бол, жил тутам дээшилсээр 2015 оны 3-р сард газар ашиглалтын захиргааны байгууллагуудын араас хоёрдугаарт, нэг жилийн дараа нэгдүгээрт, харин 2017 онд хоёрдугаарт жагсжээ. Монголын иргэд улс төрийн нам, газар ашиглалтын байгууллагуудыг хамгийн их авлигатай гэж тодорхойлжээ. Улс төрийн намуудыг авлигаас хэрхэн ангид байлгаж чадах эсэх нь ардчилсан монголын өнөөгийн хамгийн тулгамсан асуудал болоод байна.

Улс төрийн намуудын өнөөгийн энэ нөхцөл байдлыг өөрчлөхийн тулд юу хийх ёстой вэ? Энэ асуултын хариуг урт хугацаанд эрж хайсны эцэст, зөвхөн нийт иргэдийн тасралтгүй хяналт, шахалт шаардлага юм гэсэн дүгнэлтэнд бид хүрсэн юм. Харин тийм хяналт шахалт хийхэд иргэдэд бодитой баримт, судалгаа хэрэгтэй. Тийм баримт судалгааны нэг нь улс төрийн намуудын дотоод ардчиллын индекс байж болох юм гэж бид үзсэн юм.

Улс төрийн нам бол бүх нийтийн чөлөөт сонгуулиар төрийн эрх мэдлийг авдаг цорын ганц байгуулал учир ардчилсан дэглэмийн хамгийн чухал институт юм. Гэтэл улс төрийн намууд нь өөрсдөө ардчилсан биш бол, ардчилсан сонгууль ч утга учраа алдана. Нэгэнт сонгууль утгагүй учиргүй болчихвол ардчиллын үнэ цэн алдагдана. Тийм учраас Монголчуудадулстөрийн намуудаа нээлттэй, ил тод, тайлагнадаг, хариуцлагатай институт болгож төлөвшүүлэхэд гар бие оролцохоос өөр сонголтгүй ажээ.

Уг индексийг бид жил бүр тогтмол гаргах болно. Энэ судалгааны үндсэн зорилго нь улс төрийн намууд өөрсдийг байгууллын хувьд уlam төлөвшүүлэхэд нь түлхэж, тодорхой хувь нэмэр болох явдал юм. Наад зах нь, улс төрийн намуудын жирийн гишүүдийн улс төрийн боловсролыг нэмэгдүүлэхэд тус дэм болно гэдэгт итгэлтэй байна. Намуудын төлөвшлийн зургийг гаргалаа гээд намууд өөрчлөгдөх эсэх нь идэвхитэй иргэд, хэвлэл мэдээллийн байгууллагууд энэ судалгааг хэрхэн ашиглахаас хамаарах тул холбогдох бүх талууд идэвхитэй оролцоно гэдэгт гүнээ итгэж байна. Манай судалгаатай холбоотой санал хүсэлтээ erdenedalai.b@ufe.edu.mn болон origo@jargaldefacto.com хаягаар илгээнэ юу.

СУДАЛГААНЫ ХУРААНГҮЙ

Уг судалгаагаар Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллыг оролцоо, өрсөлдөөн, ил тод байдал, санхүүжилт зэрэг дөрвөн гол үзүүлэлтээр үнэлэн индекс гаргахыг зорилоо. Монгол Улсын Дээд шүүхэд бүртгэлтэй 28 улс төрийн намаас 6 нь энэ судалгаанд хамрагдсан болно. Улс төрийн намуудын дотоод ардчилалд тулгарч байгаа саад бэрхшээл, болон цаашид юунд тулхүү анхаарах ёстойг уг судалгаанд тусгасан болно. Монголын улс төрийн намуудын дотоод ардчилал хэлбэр төдий байгаа нь иргэдийн улс төрийн мэдлэг боловсрол, соёлтой холбоотой байна. Мөн улс төрийн намуудын үйл ажиллагаа ихэвчлэн дээрээс доош чиглэлтэй байгааг энэхүү судалгаа харууллаа.

- Улс төрийн намын гишүүдийн оролцоо гэсэн 20 хүртэлх оноо бүхий хэмжигдэхүүнээр судалгаанд оролцсон 6 улс төрийн нам дунджаар 10.25 оноотой байна.
- Улс төрийн нам доторх өрсөлдөөн гэсэн 24 оноотой хэмжигдэхүүнээр судалгаанд оролцсон 6 улс төрийн нам дунджаар 16.28 оноотой байна.
- Улс төрийн намын ил тод байдал гэсэн 24 оноо бүхий хэмжигдэхүүнээр судалгаанд оролцсон 6 улс төрийн нам дунджаар 9.26 оноотой байна.
- Улстөрийн намын санхүүжилт гэсэн 32 оноог эзлэх хэмжигдэхүүнээр судалгаанд оролцсон 6 улс төрийн нам дунджаар 10.78 оноотой байна.

Нийт 100 хүртэлх оноо бүхий хэмжигдэхүүнүүдийн нийлбэрээс судалгаанд оролцсон 6 улс төрийн нам дунджаар 49.9 оноотой байна.



СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Дефакто Институтийн эрхэм зорилго бол Монгол улсад сайн засаглалыг бэхжүүлэх бөгөөд уг зорилгодоо хүрэх эсэх нь улс төрийн намуудыг нээлттэй, хариуцлагатай улс төрийн институт болгох эсэхээс хамаарна гэж үздэг. Бид олон улсын болон дотоодын судалгааны байгууллага, судлаачдын улс төрийн намуудын төлөвшил, дотоод ардчиллын чиглэлээр хийсэн бүтээлүүдтэй танилцан харьцуулсны үндсэн дээр Израйль улсын "Ардчилал" институтийн "Улс төрийн намуудын дотоод ардчиллын индекс"-ийг жишиг болгон Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын индексийг гаргахыг зорьсон юм. Улмаар Израйлийн "Ардчилал" институттэд хандаж судалгааны арга зүйн талаар илүү мэдээлэл, зөвлөгөө авч, хамтарч ажилласан. Олон улсын жишигт индексийг гаргахдаа экспертийн дүгнэлт дээр үндэслэн гаргадаг. Харин манай улсад улс төрийн намыг тэр тусмаа намын дотоод ардчиллыг судалдаг, аль нэг намын харьяалалгүй эксперт тун цөөн байгаа учир арга зүйн хувьд "Ардчилал" институтийн экспертийн үнэлгээний аргачлал Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллыг үнэлэхэд тохиромжгүй байсан юм.

Тиймээс бид энэхүү улс төрийн намын дотоод ардчиллын индексийг тодорхойлохдоо намын гишүүдээс асуулгын аргаар судалгааг авлаа. Ингэхдээ телемаркетингийн аргыг ашиглан утсаар холбогдож, дуудлага хийн мэдээллүүдээ цуглуулсан. Судалгааны арга зүй болон судалгаанд оролцогчдоос авах асуулга, хариултуудад харгалзах оноог гаргахдаа мэргэжлийн судлаачдаас арга зүйн дэмжлэг авч, хэлэлцүүлсний үндсэн дээр боловсруулав.

Израйлийн "Ардчилал" институт улс төрийн намуудын дотоод ардчиллыг тодорхой үзүүлэлтүүдийн дагуу нийт 100 оноогоор үнэлдэг бөгөөд энэ шалгуурыг үндэс болгон Монголын намуудын дотоод ардчиллыг үнэллээ. Үүнд:

- 30 хүртэлх оноо авсан бол ардчилалгүй нам,
- 31-60 оноо авсан бол хагас ардчилалтай нам,
- 61-ээс дээш оноо авсан бол ардчилалтай нам

Үүнээс гадна улс төрийн намуудын дотоод ардчилал, санхүүжилтийн өнөөгийн нөхцөл байдлыг тайлбарлах, учир шалтгааныг тодорхойлох зорилгоор чанарын судалгааны арга буюу хагас бүтэцлэгдсэн, нээлттэй ярилцлагын аргыг ашиглан экспертуудээс судалгааг авсан болно.

Энэхүү судалгаанд 2018 оны хоёрдугаар сарын байдлаар Монгол Улсын Дээд шүүхэд бүртгэлтэй 28 намыг хамруулахаар судалгааны баг зорьж улмаар 2-3 удаагийн хандалт хийсэн боловч тодорхой шалтгааны улмаас улс төрийн намуудын дарга нар гишүүдийнхээ утасны дугаарыг өгөхөөс татгалзах нь их байсан бөгөөд судалгааны багийн удаа дараагийн уйгагүй оролдлогын үр дүнд улс төрийн зургаан намыг хамруулав.

Судалгааны түүврийн хувьд судалгаанд оролцох боломжтой нийт 6 намын гишүүд буюу эх олонлог 535324 хүн байна. Үүнээс түүврийн хэмжээг гаргахдаа үнэмшлийн түвшин 95%, алдааны нарийвчлал 5% байхаар тооцсон. Ингээд нийт түүврийн хэмжээ нь 384 байна. Эдгээр түүврээ санамсаргүй сонгохдоо Улаанбаатар хот болон орон нутгийн намын гишүүд нийлээд 3000 гаруй нэр, утасны дугаар цуглуулан судалгааг авсан.

Экпертийн ярилцлагын хувьд улс төрийн ухааныг судалдаг, улс төрийн намуудын дотоод үйл ажиллагааг мэддэг судлаачдаас зориуд буюу санамсаргүй бус түүврийн аргаар 10 экспертийг сонгон хагас бүтэцлэгдсэн ярилцлага хийсэн. Экспертийг сонгохдоо аль болох улс төрийн шинжлэх ухааны мэргэжилтэй, судлаач байх, судлаачдын намын харьялал тэнцвэртэй байх гэсэн шаардлага тавьсан. Ярилцлагын чиглүүлэх асуултуудыг Израилийн "Ардчилал" институтийн үндсэн асуултуудтай уялдуулж гаргасан. Судалгааны ярилцлагыг эксперт болгонтой хийсний дараа ярилцлага бүрийг Nvivo програмыг ашиглан утгаар нь кодолсон бөгөөд түүн дээр үндэслэн дүгнэлт гаргасан болно.

УЛС ТӨРИЙН НАМЫН ДОТООД АРДЧИЛЛЫН ИНДЕКС

Улс орны ардчиллыг бүхэлд нь үнэлэх хэд хэдэн аргыг олон улсад ашиглаж байна. Жишээлбэл, Freedom House хараат бус, хөндлөнгийн хяналтын байгууллага “Дэлхийн эрх чөлөөний тайланг”, мөн Economist Intelligence Unit байгууллага “Ардчиллын индекс” тайланг гаргадаг. Израйл улсын “Ардчилал” институт “Улс төрийн намын дотоод ардчиллын индекс”-ийг 2013 онд анх гаргажээ. Энэхүү индекс нь тус институтийн Улс төрийн шинэчлэлийн төслийн хүрээнд хийгдсэн улс төрийн намын дотоод ардчилалд үнэлэлт, дүгнэлт өгөхөөр боловсруулагдсан анхны тайлан юм. Нам доторх ардчиллыг хэмжих шалгууруудыг тодорхойлоходоо асуулгуудыг үзүүлэлт бүрт ялгаатай үнэлгээ өгөхөөр боловсруулсан байна.

Орчин үеийн төлөөллийн ардчиллыг хөгжүүлэх, улс орон нь ардчилсан шийдвэр гаргахад улс төрийн намууд нь голлох үүрэг гүйцэтгэдэг. Шинэ, залуу ардчилсан орнуудад улс төрийн намуудын оролцоо, төлөвшил түүхэн чухал үүрэгтэй ажээ. Улс төрийн намууд зөвхөн парламентийг бүрдүүлэхээс гадна иргэд, олон нийтийн хүсэл зоригийг нэгтгэх, сонгогчдыг төлөөллийн үүргээ биелүүлж, иргэдийг төртэй холбож өгөх, түүнчлэн ирээдүйн нэр дэвшигчдийг татан элсүүлэх арга хэрэгсэл болдог зуучлагч институт юм (Rahat & Shapira 2016).

Намын дотоод ардчилал гэсэн нэр томьёо нь улс төрийн намууд доторх шийдвэр гаргалт, зөвлөлдөхөд намын гишүүдийг хамруулж байгаа өргөн хүрээний үе шатуудаар тодорхойлогоно. Намын дотоод ардчиллын шалгуурт нам доторх эрх мэдлийн хуваарилалт, ялангуяа анхан шатны гишүүдийн оролцоог нарийн тооцдог. Тухайлбал, намын дарга болон намаас аль нэг түвшиний сонгуульд нэр дэвшигчдийг тодруулахад санал өгч буй гишүүдийн хүрээ чухал үүрэгтэй. Парламентийн бүх нийтийн сонгуульд иргэн бүр саналаа өгөх эрхтэй байх нь ардчиллын үндсэн зарчим бол улс төрийн нам доторх нэр дэвшигчид болон намын даргыг сонгоход энэ асуудал намуудын дунд харилцан адилгүй байна. Улс төрийн намын тухай хуулиар намын гишүүд ямар түвшинд хамрагдсан байхыг нарийн тодорхойлоогүй байдаг. Шууд эсвэл төлөөллийн байдлаар сонгогдсон байхыг л ерөнхийд нь шаарддаг байна. Улс төрийн нам бол өөрсдийн хүсэл зориг, сонирхлоороо эвлэлдэн нэгдсэн иргэд, тэдгээрийн холбоо учир үйл ажиллагаагаа өөрсдийн сонголтоороо зохион байгуулахад чөлөөтэй байх шаардлага тавьдаг. Намууд төлөөллийг хэрэгжүүлэхдээ янз бүрийн арга хэрэглэж байна.

A. ОРОЛЦОО

Оролцоо нь улс төрийн шийдвэр гаргалтад шууд болон шууд бусаар нөлөөлөхүйц олон төрлийн үйл ажиллагааг хамрах өргөн хүрээний ойлголт юм (Rahat & Shapira 2016). Уг индекст төлөөллийн ба шууд гэсэн ерөнхий 2 хэлбэрийн аль нэгийг давуу байдлаар үнэлэхээс зайлсхийж ижил оноогоор үнэлэхдээ намын гишүүдийн энэ хоёр төрлийн оролцооны тохиолдлыг шинжиллээ. Нэгдүгээрт, намын үзэл баримтлалтай холбоотой хэлэлцүүлгүүд буюу намын мөрийн хөтөлбөр, сонгуулийн мөрийн хөтөлбөр болон нам доторх бодлогын мэтгэлцээнүүдийг хамруулсан болно. Улс төрийн намын дотоод ардчиллыг бодитойгоор хэрэгжүүлэхийн тулд иргэд, олон нийтийн оролцоог зөвхөн хууль, дүрмийн хүрээнд баталгаажуулахаас гадна бодлого боловсруулах үйл явцад тэдгээрийн идэвхтэй оролцоог хангах нь чухал байдаг. Энэ утгаараа намын бодлогын баримт бичгүүдэд хэлбэр төдий бус, бодитой оролцоог шинжлэхийн тулд

боловсруулах болон батлах гэсэн үйл явцыг тусад нь авч үзсэн болно. Үүнээс гадна бодлогын хэлэлцүүлгүүдэд гишүүдийг бодитойгоор оролцуулах нь олон нийтийн улс төрийн боловсролд чухал юм. Хоёрдугаарт, намын гол шийдвэр гаргагчид нь намын дарга болон намаас УИХ-ийн сонгуульд өрсөлдөх эрх авсан нэр дэвшигчид учир эдгээр хүмүүсийг сонгоход гишүүд хэр нөлөөтэй оролцож байгааг шинжилсэн болно.

Б. ӨРСӨЛДӨӨН

Улс төрийн намын дотоод ардчиллыг хэмжихэд дараачийн чухал хэмжигдэхүүн нь өрсөлдөөн юм. Энэ нь сонгогчид саналаа өгөх хэд хэдэн хувилбартай байхыг хэлнэ. Ингээд намын дарга, удирдах зөвлөл зэрэг намын дотоод удирдлага, зохион байгуулалтын бүтцийн голлох албан тушаалуудад сонгууль явагдсан эсэх, мөн Ерөнхийлөгчийн, УИХ-ын, орон нутгийн сонгуулиудад нэр дэвших боломж намын гишүүдэд нээлттэй байдлыг шинжилсэн.

В. ИЛ ТОД БАЙДАЛ

Энэ хэсэгт бид улс төрийн намын эгэх хариуцлага, төлөөлөл, ил тод байдал зэрэг чиглэлүүдийг нэгтгэн оруулсан. Учир нь тухайн Аргчилал институтын судалгааны асуулгын хүрээнд эгэх хариуцлага (accountability гэдгийн шинэ орчуулга), төлөөлөл гэсэн хоёр чиглэл цөөн асуултуудтай байсан учраас нэгтгэсэн. Ил тод байдал гэх хүрээнд тухайн нам гишүүддээ болон олон нийтэд үйл ажиллагаагаа хэр нээлттэй явуулдаг болохыг хэмжсэн. Жишээлбэл, нам доторх хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлдэг бүтэц байдаг эсэх, намын жирийн гишүүдэд үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлантай танилцах боломж байдаг эсэхийг тодруулсан болно.

Г. САНХҮҮЖИЛТ


Улстөрийн намын дотоод ардчиллыг хэмжих судалгаанд намын санхүүжилтийн хэсгийг бид нэмж оруулсан болно. Учир нь манайд улс төрийн намын санхүүжилтийн эх үүсвэр намын үйл ажиллагаа, дотоод ардчилалд хамгийн ихээр, шууд нөлөөлж байгаа хүчин зүйл болох нь олон төрлийн судалгаагаар тогтоогдсон юм. Энэ хүрээнд бид гишүүдийн татвар болон хандив төлдөг эсэх, төлсөн татвар болон хандивын зарцуулалтын талаарх мэдээллийг авдаг эсэх, нам гишүүддээ зардлын тайлангаа тайлагнадаг эсэх зэрэг асуултыг багтаасан болно. Намын гишүүд санхүүжилтийн талаар мэдлэг, ойлголттой болвол намынхаа удирдлагуудыг шахаж, шаардан энэ талын мэдээлэл зөвхөн намын гишүүд бус сонгогчдод нээлттэй болж тухайн нам дотоод ардчилалтай буюу ардчилал бэхжих суурь бурдэх юм.

ТООН СУДАЛГААНЫ


ҮРДҮН

1.1 СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН МЭДЭЭЛЭЛ


Зураг 1.1 Судалгаанд оролцогчид, насны бүлгээр




Зураг 1.2 Судалгаанд оролцогчид, хүйсээр





Зураг 1.3 Судалгаанд оролцогчид, ажил эрхлэлтээр



Зураг 1.4 Судалгаанд оролцогчид, байршилаар




Зураг 1.5 Судалгаанд оролцогчид, намын харьяаллаар**Зураг 1.6** Судалгаанд оролцогчид, боловсролоор


1.2 УЛС ТӨРИЙН НАМЫН ДОТООД АРДЧИЛЛЫН ИНДЕКС

Нийт хэмжигдэхүүнүүдийн нийлбэр 100 онооноос Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын индекст хамрагдсан нийт 6 намын дундаж оноо 49.9 байна. Судалгаанд оролцсон улс төрийн нам тус бүрийн оноог зураг 2.1-т харууллаа. Тус бүрдээ үнэлгээ бүхий 4 шалгуур үзүүлэлтүүдийн нийлбэр 100 онооноос судалгаанд багтсан 6 улс төрийн нам 60-аас дээш оноо аваагүй нь хагас арчилсан ангилалд багтаж байна.

Зураг 2.1 Судалгаанд оролцсон улс төрийн намуудын авсан оноо




Зураг 2.2 Судалгаанд оролцсон улс төрийн намуудын дотоод ардчиллын индекс




1.3 УЛС ТӨРИЙН НАМЫН ГИШҮҮДИЙН ОРОЛЦОО

Улс төрийн намын гишүүдийн оролцоо гэсэн 20 оноотой хэмжигдэхүүнээр судалгаанд оролцсон 6 улс төрийн нам дунджаар 10.25 оноотой байна. Индекст хамрагдсан улс төрийн нам тус бүрийн энэхүү хэмжигдэхүүнээр авсан оноог зураг 3.1-т харууллаа.


Зураг 3.1 Судалгаандаа оролцсон улс төрийн намын гишүүдийн оролцоо (20 оноо)




Зураг 3.2 Намын даргыг хэн сонгогдог вэ (5 оноо)




Зураг 3.3 Намаас УИХ-д нэр дэвшигчдийг хэн тодруулдаг вэ (5 оноо)



Зураг 3.4 Намын мөрийн хөтөлбөрийг батлахад хэн оролцдог вэ (2.5 оноо)




Зураг 3.5 Өнгөрсөн 4 жилд улс төрийн нам дотроо явуулсан бодлогын мэтгэлцээнүүдэд хэн оролцсон бэ (5 оноо)





1.4 УЛС ТӨРИЙН НАМ ДОТОРХ ӨРСӨЛДӨӨН


Улс төрийн намын дотоод ардчиллын индекст 24 оноог эзлэх уг шалгуур үзүүлэлтээс судалгаанд хамрагдсан б улс төрийн нам дунджаар 16.28 оноог авсан байна. Тус бүрдээ 4 оноо бүхий 6 асуулттай шалгуур үзүүлэлтээс судалгаанд оролцсон б улс төрийн намын авсан оноог зураг 4.1-т харууллаа.

Зураг 4.1 Судалгаанд оролцсон улс төрийн нам доторх өрсөлдөөн (24 оноо)




Зураг 4.2 2016 оны УИХ-ын сонгуулиас хойш намын даргын сонгууль явагдсан уу (4 оноо)**Зураг 4.3** 2016 оны УИХ-ын сонгуулиас хойш удирдах зөвлөлийн сонгууль явагдсан уу (4 оноо)


Зураг 4.4 Намын дотоод бүтцийн (Залуучуудын, ахмадын, эмэгтэйчүүдийн байгууллага) сонгуульд нэр дэвших боломж намын гишүүдэд нээлттэй юу (4 оноо)




Зураг 4.5 Намаас ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх эрх авах боломж намын гишүүдэд нээлттэй юу (4 оноо)



Зураг 4.6 Намаас УИХ-ын сонгуульд өрсөлдөх эрх авах боломж намын гишүүдэд нээлттэй юу (4 оноо)




Зураг 4.7 Намаас орон нутгийн сонгуульд өрсөлдөх эрх авах боломж намын гишүүдэд нээлттэй юу (4 оноо)




1.5 УЛС ТӨРИЙН НАМЫН ИЛ ТОД БАЙДАЛ

Улс төрийн намын ил тод байдал гэсэн 24 оноотой хэмжигдэхүүнээс судалгаанд хамрагдсан 6 улс төрийн нам дунджаар 9.26 оноотой байна. Нам тус бүрийн уг хэмжигдэхүүнээр авсан оноог зураг 5.1-т харууллаа.


Зураг 5.1 Судалгаандаа оролцсон улс төрийн намын ил тод байдал (24 оноо)




Зураг 5.2 Намд дараах дотоод бүтцийн байгууллагууд байдаг уу (3 оноо)




Зураг 5.3 Өнгөрсөн 4 жилийн хугацаанд намын дотоод бүтцийн сонгууль явагдсан уу (3 оноо)





Зураг 5.4 Нам доторх хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлдэг бүтэц
(Ёс зүйн хороо, Сахилгын хороо гэх мэт) ажилладаг уу (3 оноо)




Зураг 5.5 Намынхаа дүрэмтэй танилцсан уу (5 оноо)



Зураг 5.6 Намынхаа үйл ажиллагааны тайлантай танилцах боломж байдаг уу (4 оноо)**Зураг 5.7** Намын интернет орчин дахь мэдээлэл (4 оноо)


Зураг 5.8 Намын өдөр тутмын үйл ажиллагаа, шийдвэрүүдтэй танилцдаг эх сурвалж (6 оноо)




1.6 УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТ

Энэхүү индекст хамгийн өндөр оноог эзэлж буй улс төрийн намын санхүүжилт гэсэн 32 оноотой хэмжигдэхүүнээр нийт 6 намын дундаж оноо 10.78 байна. Тус бүрдээ 4 оноотой 8 асуулт бүхий шалгуур үзүүлэлтээс судалгаанд хамрагдсан 6 улс төрийн нам тус бүрийн авсан оноог зураг 6.1-т харуулав.


Зураг 6.1 Судалгаандаа оролцсон улс төрийн намын санхүүжилт (32 оноо)




Зураг 6.2 Намдаа гишүүний татвараа төлдөг үү (4 оноо)




Зураг 6.3 Намдаа хандив өгдөг үү (4 оноо)




Зураг 6.4 Өөрийн төлсөн гишүүний татвар, хандивын талаарх зарцуулалтын мэдээллийг авдаг уу (4 оноо)




Зураг 6.5 Нам хөрөнгө, орлого, зарлагын мэдээллээ гишүүддээ тайлагнадаг уу (4 оноо)





Зураг 6.6 Гишүүд намынхаа санхүүжилтийн талаарх мэдээлэл авах боломж байдаг уу (4 оноо)



Зураг 6.7 Нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлантай танилцдаг уу (4 оноо)



Зураг 6.8 Намынхаа сонгуулийн зардлын тайлантай танилцдаг уу (4 оноо)**Зураг 6.9** Төрөөс намд олгож буй санхүүжилтийн тайлантай танилцдаг уу (4 оноо)

2. ЭКСПЕРТИЙН ЯРИЛЦЛАГА

Судалгааны энэ хэсэгт улс төрийн намуудын дотоод ардчиллын өнөөгийн байдлыг учир шалтгаан талаас нь тайлах зорилгоор экспертийн ярилцлагыг нийт 10 эксперттэй хийж гүйцэтгэсэн. Уг ярилцлагуудыг утгаар нь кодлон түүн дээрээ үндэслэн дүгнэлт гаргасан болно. Экспертүүдтэй ярилцлага хийхэд гарсан гол хүндрэл бол манайд намын дотоод ардчиллыг тухайллан судалдаг хүн цөөн байсан. Тиймээс тодорхой намын дотоод үйл ажиллагаа, дотоод ардчиллыг мэддэг байх гэсэн шалгуураар экспертуудээ сонгосон.

УЛС ТӨРИЙН НАМ БА БҮТЭЦ

1. Улс төрийн намуудын, ялангуяа хоёр том намын тухайд дотоод ардчиллыг нь тодорхойлж байгаа гол хүчин зүйл бол төр шиг, аль эсвэл альтернатив төрийн бүтэц. Энэ бүтэц нь коммунист нийгмийн ганц намтай системээс үлдсэн хэлбэр юм. Одоо байгаа хоёр том намаас бусад жижиг намуудын тухайд бол харьцангуй уян хатан, цомхон бүтэц байна. Тухайлбал, эксперт #10: "Одоогийн намын бүтэц бол ганцхан намтай байх үеийн бүтэц буюу альтернатив төрийн бүтэц юм. Орчин үеийн намын бүтэц биш альтернатив төрийн бүтэц. Ялсан тохиолдолд эрх мэдлийг бүхлээр нь ав, бусад үед бүгд хаягддаг тогтолцоо. Төр манайд ямар бүтэцтэй байдаг вэ? Жишээ нь нийслэлийн намын хороо гэж байна. Энэ нь нийслэлийн эрх мэдлийг авна л гэсэн үг."
2. Намын гишүүдийн сэтгэлгээнд улс төрийн нам хэрхэн зохион байгуулагдсан байх ёстой зэрэг ойлголтууд өмнөх нийгмийн үеийнхээс өөрчлөгдөөгүй байна гэж үзэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, улс төрийн намын гишүүдэд улс төрийн боловсрол хангалттай очиж чадахгүй байна. Эксперт #2 "Улс төрийн нам дотор хамтын удирдлагын шийдвэр явагдахгүй байна гэдэг нь гишүүд оролцохгүй байна л гэсэн үг. Харин ч даргаа яах юм бэ гээд байж байна. Үүнийг ямар нэг хувь хүнээр төлөөлүүлж буруутгах хүнд юм. Иймээс улс төрийн боловсролыг олгох ажил хэрэгтэй байна. Энэ нь бас л өртөгтэй. Ийм зардууд намуудад байхгүй. Жишээ нь, сумын намын байрны өдөр тутмын зардал л гэхэд хүнд шүү дээ."
3. Нэгэнт улс төрийн намууд данхар том бүтэцтэй, түүнийг дагасан паразит давхаргатай учраас тэднийг тэжээх, улс төрийн эрх мэдэл авах зорилгынхoo төлөө далд санхүүжилт авдаг гэж харж болно. Улс төрийн намууд санхүүгийн тайлангаа олон нийтээс нуудаг нь далд санхүүжилттэй холбоотой гэж экспертууд дүгнэж байна. Тухайлбал, эксперт #5: "Хамгийн хэцүү асуудал нь намын санхүүжилтийн цаана асар олон паразитууд амьдарч байгаа. Хэвлэл мэдээллийнхэн тэр чигээрээ сонгууль болоосой гэж хүлээж байна. Үүн дээр нэмээд урлагийнхан байна. Өөрөөр хэлбэл, улс төрийн намыг энэ олон паразитууд шимэгчлээд байна. Энэ их шимэгчдийн дунд ямар нэгэн аргаар их мөнгө олохгүй бол болохгүй."

УЛС ТӨРИЙН НАМЫН ОРОЛЦОО БА ӨРСӨЛДӨӨН

1. Улс төрийн намууд доторх өрсөлдөөн нь тодорхой элит, мөнгөтэй хэсгүүд буюу фракцуудын хоорондын өрсөлдөөн, ашиг сонирхлын нэгдлээр илэрч байгааг харуулж байна. Гэхдээ энэ өрсөлдөөнд улс төрийн эрх мэдэл олж авах гэсэн зорилгын дор намын гишүүдийн тухайн гишүүний улс төрийн капитал, мөнгөний чадавх (Энд дэнчин хамаарна) зэргээс хамаарч сонгодог. Тиймээс улс төрийн нам дотор өрсөлдөөн хэлбэр төдий л байна гэж экспертууд дүгнэсэн. Тухайлбал, эксперт #1: “Тэгэхээр бүх гишүүдийн оролцоог харахаар АН-ын даргыг сонгоход бүх гишүүдийн оролцоог хангасан мэт хэлбэрээр явагдлаа. Гэхдээ тэр нь эргээд өөрийнхөө гишүүдийн саналыг худалдаж авсан хэрэг болж байна.”

ХЯНАЛТ БА ТАЙЛАГНАЛ

1. Улс төрийн намууд гишүүддээ болон олон нийтэд үйл ажиллагаа, санхүүжилтээ тайлagnадаг, ил тод байлгахын тулд институтийн хүчин зүйл тун чухал. Гэтэл улс төрийн намууд үйл ажиллагаагаа хэрхэн тайлagnах талаарх хуулийн зохицуулалт бүрхэг, хуулийн зохицуулалт бараг байхгүй зэрэгтэй холбоотой гэж экспертууд дүгнэсэн. Тухайлбал, эксперт #3: “Өмнө жил АН-ынхан шилэн болж байгаа нь гээд тайлангаа вебсайт дээр тавьчихсан гэж байсан. Веб сайт руу нь ороод харахад цугларсан мөнгөө жагсаагаад тавьчихсан байсан. Ямар ч байсан нэг юм гаргах нь гаргаад байгаа ч стандарт байхгүй. Энэ нь санамсаргүй маягтай ямар нэгэн систем байхгүй нь харагдаж байгаа юм.”
2. Намын дотоод ардчиллыг амжилттай хэрэгжүүлэхэд нам доторх дотоод хяналтын байгууллагын үйл ажиллагаа чухал. Гэтэл одоогоор тэдний чиг үүрэг тодорхой биш, намын жирийн гишүүдийн хяналт ч сул байна. Энэ нь мөн намын гишүүдийн улс төрийн боловсролтой холбоотой. Тухайлбал, эксперт #8 хэлэхдээ: “Намын хяналтын байгууллага нь дотроо санхүүгийн хяналтын дэд хороо, ёс зүй сахилга батын дэд хороо, намын дунд шатны байгууллага гэх үндсэн З хороонд хуваагдан 15 хүний бүрэлдэхүүнтэй байдаг. Намын дарга нь эдгээр хүмүүсээс шаардлага хангасан нэр дэвшигчдийн жагсаалтаас 15 хүнийг намын их хуралд санал болгон батлуулна. Тэгэхээр намын дарга нь л дотоод хяналтын байгууллагад хэн орох вэ гэдгийг шийдэж байна шүү дээ. Уг нь намын хяналтын байгууллага чинь намынхаа даргыг хянахын тулд байх ёстой.”

Монголын улс төрийн намыг судалдаг судлаач, экспертуудтэй ярилцсанаар дээрх дүгнэлтүүдийг хийж болохоор байна. Гэхдээ энд бид бүх улс төрийн намуудыг нэгтгэн дүгнэх ямар ч боломжгүй. Учир нь олон шинэ, эсвэл жижиг намуудын хувьд улс төрийн намын хэв загвараа олох болоогүй л байна. Тэдгээр намуудад улс төрийн намын дотоод ардчиллыг ярих боломжгүй гэдэг дээр манай экспертууд санал нэгдэж байсан. Харин хоёр том нам, жижиг намуудын тухайд дотоод ардчиллын ерөнхий дүр зураг нь дээрээс доош чиглэсэн байдалтай байна. Жишээлбэл, эксперт #1-ийн хэлснээр “МАН-ын сүүлийн 2 даргын сонголтыг харахаар дахиад доороосоо дээшээ гэхээс илүү дээрээсээ доошоо хийгдчихсэн, тохирсоны дараагаар сонголт хийгдэж байна.”

Өрсөлдөөн нь хэвтээ буюу фракцууд хоорондын тэмцэл бас зөвшилцэл дээр суурилж байна гэж судлаачид дүгнэсэн.

ДҮГНЭЛТ

- Улс төрийн намуудын дотоод ардчиллын индексийг тодорхойлох судалгааг Улаанбаатар хотын болон Хөвсгөл, Баянхонгор, Орхон, Дорнод, Булган аймагт оршин суудаг улс төрийн намын гишүүдийн төлөөллийг хамруулан гүйцэтгэлээ. Судалгаанд оролцогчид:
 - Байршлын хувьд хотоос 57.6%, орон нутгаас 42.3% хамрагдлаа.
 - Насны бүлгийн хувьд 26-65 насын гишүүдээс 16.9%-33.1% хүртэл буюу бүх насын төлөөлөл хамрагдлаа.
 - Хүйсийн хувьд эрэгтэй 53%, эмэгтэй 47% хамрагдлаа.
 - Боловсролын хувьд дээд боловсролтой гишүүд 86.7%-ийг эзэлж байна.
 - Ажил эрхлэлтийн хувьд бүх салбарт ажиллаж буй гишүүд хамрагдлаа.
- Улс төрийн намуудын үйл ажиллагаа, дотоод ардчиллыг оролцоо, өрсөлдөөн, ил тод байдал, санхүүжилт гэсэн дөрвөн гол үзүүлэлт тус бүрт судалгааны арга зүйн дагуу тодорхой оноо өгөн дүгнэсэн болно. Израйл улсын “Ардчилал” институт судалгаандаа намуудыг дараах байдаар гурав ангилсан байдаг. Үүнд:
 - 61 - 100 оноо авсан бол ардчилалтай нам
 - 31 - 60 оноо авсан бол хагас ардчилалтай нам
 - 30 хүртэлх оноо авсан бол ардчилалгүй нам

Дээрх ангиллыг харвал судалгаанд хамрагдсан 6 нам “хагас ардчилсан” гэдэг ангилалд хамрагдаж байна. Улс төрийн 6 намын гишүүдээс авсан асуулгаар нийт 100 онооноос:

1. АН - 54,2 оноо
2. МАХН - 51,7 оноо
3. ЭОН - 51,4 оноо
4. ХҮН - 51,2 оноо
5. МАН - 48,2 оноо
6. ИЗН - 42,7 оноог тус бүр авлаа.

Эндээс улс төрийн намуудын авсан онооны хооронд зөрүү их гараагүй, дотоод ардчиллын түвшин тун ойролцоо буюу хангалтгүй түвшинд байна.

- Улс төрийн намуудын дотоод ардчиллын индексийг тодорхойлох судалгаанд хамрагдсан намуудыг авсан оноогоор дүгнэж болох ч оролцоо, өрсөлдөөн, ил тод байдал, санхүүжилт гэсэн 4 үзүүлэлт тус бүр дээр нам бүрийн авсан оноо харилцан адилгүй, өөрчлөлтэй гарсныг анхаарах хэрэгтэй.

Дээрх үзүүлэлт тус бүр дээр намууд нийтдээ хэдэн оноо авсныг гаргавал:

- Өрсөлдөөн – 98.4 оноо
- Ил тод байдал – 75.4 оноо
- Санхүүжилт – 64.7 оноо
- Оролцоо – 60,9 оноо

• УЛС ТӨРИЙН НАМ ДОТОРХ ӨРСӨЛДӨӨН

МАН, АН-ын хувьд олон тооны гишүүдтэй учраас бүх түвшний сонгуульд өрсөлдөх эрх намын гишүүдэд нээлттэй бус, нэр дэвшигчдэд тавигдах босго шалгуур өндөр буюу намдаа өгч буй дэнчингээс хамааралтай болдог байна. Харин жижиг улс төрийн намуудын хувьд бүх түвшний сонгуульд өрсөлдөх эрх харьцангуй нээлттэй, нэр дэвшигчдэд тавигдах шалгуур харьцангуй бага болох нь ажиглагдлаа.

• УЛС ТӨРИЙН НАМЫН ИЛ ТОД БАЙДАЛ

Судалгаанд хамрагдсан б улс төрийн намаас З нам вэб сайттай, мэдээлэл байршуулдаг буюу олон нийтэд тодорхой хэмжээнд (өнгөц) нээлттэй байдаг. Намын гишүүдийн хувьд намын үйл ажиллагааны мэдээлэл, тайлантай танилцах боломж сонгуульт гишүүдийн хувьд тодорхой хэмжээнд нээлттэй буюу дотоод сүлжээ, фэйсбүүкийн нууц группуудээр мэдээллээ солилцдог болох нь ажиглагдлаа. Гэхдээ энэ нь намын жирийн гишүүдэд төдийлөн нээлттэй биш болох нь судалгаанаас харагдлаа.

• УЛС ТӨРИЙН НАМЫН САНХҮҮЖИЛТ

Улс төрийн намын гишүүд намдаа гишүүний татвараа төлдөг ч хандив өгөх нь бага, өөрийн төлсөн гишүүний татвар, хандивын зарцуулалтын талаарх мэдээллийг авдаггүй болох нь судалгааны дунд гарч байна. Мөн намын болон намаас нэр дэвшигчдийн зардлын тайлантай танилцах нь бага, зарим талаар шаардлагагүй гэж үзэж байсан нь харамсалтай. Нөгөө талаараа судалгаанд оролцогчид нам гишүүддээ санхүүжилтээ тайлагнадаггүй, хаалттай, сонгуульд зөвхөн мөнгөтэй хүн нэр дэвшдэг зэрэг шүүмжлэлийг хэлж байсан нь улс төрийн намын дотоод ардчилалд хамгийн нөлөөтэй энэхүү үзүүлэлт дээр бид цаашид илүү анхаарах, гишүүд сонгогчдод илүү нээлттэй болгох нь маш чухал болохыг харууллаа.

• УЛС ТӨРИЙН НАМЫН ГИШҮҮДИЙН ОРОЛЦОО

Судалгааны дүнгээс улс төрийн намын гишүүдийн оролцоо намын бүх түвшинд харьцангуй бага байгаа нь ажиглагдлаа. Намын удирдлагын түвшинд төлөөллийн зарчим хэрэгжиж байгаа ч чанарын судалгаанд оролцогчдын илэрхийлж байсан “намын бүтэц болон шийдвэр гаргах бүх үйл ажиллагаа дээрээс доош чиглэлд байна” гэсэн байр суурь батлагдлаа. Гэхдээ энэхүү судалгааг намын гишүүдээс авч улс төрийн намын дотоод ардчиллын талаар тодорхой мэдээлэл өгснөөрөө цаашид гишүүдийн оролцоо намын үйл ажиллагаанд хангалтгүй байх зэрэг гарах сөрөг үр дагавар, нөлөөнөөс зайлсхийх боломжтой. Жишээ нь, намын үйл ажиллагааны, санхүүжилтийн зэрэг тайлангуудыг нэхдэг, хяналт тавьдаг болж намын өдөр тутмын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог болох магадлалтай гэж үзэж байна.

- Уг судалгааг хийснээр судалгааны баг намын гишүүдэд улс төрийн боловсрол олгоход тодорхой хувь нэмэр орууллаа. Учир нь намын гишүүдээс судалгаа авах явцад улс төрийн намын дотоод ардчилал, санхүүжилтийн талаарх ойлголт,

“Улс төрийн намын тухай” хуулийн заалтуудыг ямар нэгэн байдлаар тайлбарлах шаардлага тулгарч байв.

- Чанарын судалгаа буюу экспертийн үнэлгээгээр улс төрийн намын дотоод ардчиллын индексийг тодорхойлох боломжгүй болох нь батлагдсан. Учир нь экспертууд ярилцлагын үед асуултад хариулахдаа:

- МАН, АН
- МАХН, ХҮН, ИЗН
- бусад намууд гэсэн байр сууринаас харж тайлбар, дүгнэлтийг хийж байв.

Эндээс парламентад суудалгүй жижиг намуудыг үнэлэхэд хүндрэлтэй, иргэдэд төдийлөн нээлттэй биш байгаа нь харагдаж байна. Чанарын судалгааны үр дүнд улс төрийн намын эрх зүйн орчныг шинэчлэн сайжруулах, яаралтай шийдвэрлэх шаардлагатай болох нь харагдлаа.

НОМ ЗҮЙ

Азийн Сан (2017) *Аялгын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа*

Гэрэлт-Од, Э. (2009) *Монгол дахь улс төрийн намуудын дотоод ардчиллын төлөөшилийн асуудал* (1990 оноос хойш)

Мөнхбат, С. (2009) *Монгол дахь улс төрийн намын бүтэц, зохион байгуулалтын төлөөшилтийн зарим асуудал*

Эрдэнэдалай, Б. (2015) *Улс төрийн намын санхүүжилт: Олон улсын туршилага ба Монгол дахь тулгамдсан асуудал*

Cross, W. & Katz, R. S. (2013) *The Challenges of Intra-Party Democracy*, Oxford, Oxford University Press.

Cross, W. (2013) 'Party Leadership Selection & Intra-Party Democracy'. In Cross, W. & Katz, R. S. (eds.) *The Challenges of Intra-Party Democracy*, Oxford, Oxford University Press, pp. 100 – 115.

Gauja, A. (2013). 'Policy Development and Intra-Party Democracy'. In William P. Cross, Richard S. Katz (eds.), *The Challenges of Intra-Party Democracy*, (pp. 116-135). Oxford: Oxford University Press.

Scarrow, S. (2005) *Political Parties & Democracy in Theoretical & Practical Perspectives: Implementing Intra-Party Democracy*

Rahat, G. & Shapira, A. (2016) *An Intra-Party Democracy Index: Theory, Design & A Demonstration*

Rahat, G. (2013) 'What is Democratic Candidate Selection?'. In Cross, W. and Katz, R. S. (eds.) *The Challenges of Intra-Party Democracy*, Oxford, Oxford University Press, pp. 136 – 149.

Van Biezen, I. & Piccio, D.R. (2013) 'Shaping Intra-Party Democracy: On the Legal Regulation of Internal Party Organizations'. In William P. Cross, Richard S. Katz (eds.), *The Challenges of Intra-Party Democracy*, Oxford, Oxford University Press, pp. 27-48.

Von dem Berge, B., Poguntke, T., Obert, P. & Tipei, D. (2013) *Measuring Intra-Party Democracy*

ХАВСРАЛТ 1. ЧАНАРЫН СУДАЛГААНД ОРОЛЦОГЧ ЭКСПЕРТҮҮДИЙН ЖАГСААЛТ

| Экспертүүд | Боловсролын зэрэг | Ажил, мэргэжил | Мэргэшил |
|------------|-------------------|----------------|---------------------|
| Эксперт 1 | Магистр | ТББ | Нийгмийн эрүүл мэнд |
| Эксперт 2 | Магистр | Судлаач | Улс төр судлал |
| Эксперт 3 | Магистр | ТББ | Төрийн удирдлага |
| Эксперт 4 | Магистр | Судлаач | Улс төр судлал |
| Эксперт 5 | Доктор | Багш, судлаач | Улс төр судлал |
| Эксперт 6 | Магистр | Хуульч | Хуульч |
| Эксперт 7 | Доктор | Багш, судлаач | Улс төр судлал |
| Эксперт 8 | Магистр | ТББ | Төрийн удирдлага |
| Эксперт 9 | Доктор | Багш, судлаач | Социологи |
| Эксперт 10 | Доктор | Багш, судлаач | Улс төр судлал |

Defacto

INDEPENDENT RESEARCH INSTITUTE

The Defacto Gazette



JARGAL DEFACTO
ГАР УТАСНЫ АППЛИКЭЙШН

МОНГОЛ, АНГЛИ, ЯПОН
ХЭЛ ДЭЭРХ 7 ХОНОГ
ТУТМЫН УЛС ТӨР,
ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХАРААТ
БУС ЦАХИМ СОНИН.



Defacto РАДИО



98.9

BUSINESS
RADIO



Defacto МЭТГЭЛЦЭЭН

MNB
MONGOLIAN NATIONAL BROADCASTER

Defacto ТОЙМ

Defacto ЯРИЛЦЛАГА

v tv HD

- <https://www.facebook.com/djargal>
- <https://www.facebook.com/defactoinstitute/>
- https://twitter.com/jargal_defacto
- <https://twitter.com/defactomn>

- Email: info@jargaldefacto.com
origo@jargaldefacto.com
- Website: www.jargaldefacto.com
www.defacto.mn